



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ**

**Чонос**  
**Болдын ЭНХЖАРГАЛ**

**КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ НЭРЛЭСЭН ҮНИЙГ  
ӨӨРЧЛӨХ ШИЙДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОН  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮР ДАГАВРЫН  
ШИНЖИЛГЭЭ**



Мэргэжлийн индекс  
042101

Эрх зүйн бакалаврын зэрэг  
Горилсон Дипломын төсөл

Удирдсан  
М.Түвшинжаргал /Ph.D/

Улаанбаатар. 2026



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ**

**Чонос**  
**Болдын ЭНХЖАРГАЛ**

**КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ НЭРЛЭСЭН ҮНИЙГ  
ӨӨРЧЛӨХ ШИЙДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОН  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮР ДАГАВРЫН  
ШИНЖИЛГЭЭ**

**В** Мэргэжлийн индекс  
042101

**Эрх Зүйн Бакалаврын Зэрэг**  
**Горилсон Дипломын Төсөл**

Удирдагч: ..... М.Түвшинжаргал /Ph.D/

Шүүмжлэгч: ..... Л.Отгонбаяр /LL.M/

## ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ .....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	v
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	vi
ОРШИЛ .....	1
Сэдэв сонгосон үндэслэл .....	1
Сэдвийн тулгамдсан байдал .....	1
Сэдвийн судлагдсан байдал.....	2
Сэдвийн хамрах хүрээ .....	2
Судалгааны ажлын зорилго .....	2
Судалгааны ажлын зорилт .....	3
Судалгааны арга зүй.....	3
Судалгааны шинэлэг тал.....	3
Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол.....	3
I БҮЛЭГ.ОНОЛЫН ХЭСЭГ .....	5
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө, түүний бүтэц.....	5
1.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийг хэмжээг өөрчлөх үндэслэл, түүний хэлбэр, бүртгэл тайлагналын онцлог .....	8
1.3 Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үеийн нягтлан бодох бүртгэлийн арга зүй, эрх зүйн зохицуулалт .....	12
II БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ .....	16
2.1 Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой шүүхийн шийдвэр хууль хэрэглээний үр дагаврын шинжилгээ .	16
2.2 Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой шүүхийн шийдвэрт хийсэн нягтлан бодох бүртгэлийн дүн шинжилгээ.....	27
2.3 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх эрх зүйн зохицуулалт бусад улсын сайн туршлага .....	28
ДҮГНЭЛТ.....	38
САНАЛ .....	40
НОМ ЗҮЙ.....	41

## МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, эдийн засгийн их сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүндээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: Б.Энхжаргал

Гарын үсэг:

Огноо: 2026.06.10

## ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын зэрэг хамгаалах судалгааны ажлыг хийхэд үнэтэй хувь нэмэр оруулж, удирдан чиглүүлж, зөвлөсөн удирдагч багш М.Түвшинжаргал (Ph.D), судалгааны ажилд шүүмж, зөвлөмж өгсөн шүүмжлэгч багш Л.Отгонбаяр (LL.M), мөн судалгааны явцад чиглүүлж, туслалцаа үзүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн ахлах багш Ж.Өлзийбаяр болон зөвлөгөө өгч туслан дэмжиж байсан Хууль зүйн сургуулийн нийт багш нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

## ТОВЧ ХУРААНГУЙ

Орчин үеийн компанийн засаглалд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх үйлдэл нь зөвхөн техникийн шинжтэй үйлдэл бус, тухайн компанийн зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн стратегийн чухал хэрэгсэл болж байна. Гэвч Монгол Улсад хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлэх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдлаас үүдэн татвар ногдох орлогод хамаарах эсэхтэй холбоотой маргаантай асуудлыг практикт бий болгож байна.

Уг маргаантай асуудлын хүрээнд шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээгээр, компанийн хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үйлдлийг шүүхийн практикт “мөнгөн бус хэлбэрээр ногдол ашиг хуваарилсан” гэж тайлбарлан татвар ногдуулж байгаа бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн суурь зарчим болох “агуулга хэлбэрээс давамгайлах” зарчимд нийцэхгүй байгаа юм. Учир нь эдийн засгийн бодит агуулгын хувьд энэ нь хувьцаа эзэмшигчдийн гар дээр шинээр хөрөнгө, мөнгө очиж буй хэрэг биш бөгөөд зөвхөн компанийн өөрийн хөрөнгийн бүтэц доторх данс хоорондын ангиллын шилжилт юм. Ийнхүү дотоод бүртгэлийн өөрчлөлтийг бодит орлого гэж үзэн татвар ногдуулах нь татвар төлөгчдөд үндэслэлгүй санхүүгийн дарамт үүсгэхээс гадна компанийн засаглалыг сайжруулах, санхүүгийн чадавхаа бэхжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Бусад улсын сайн туршлагаас үзэхэд ХБНГУ, Их Британи, Япон зэрэг улсуудад хуримтлагдсан ашгийг капиталжуулах үйл явцыг компанийн санхүүгийн бүтцийг сайжруулахад чиглэсэн “татварын саармаг” үйлдэл хэмээн хүлээн зөвшөөрч, татварын бодлогоор тусгайлан дэмждэг байна. Тиймээс энэхүү судалгаа нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцийн өөрчлөлтийг онолын түвшинд системчлэх замаар дотоодын хууль тогтоомжийн хийдлийг арилгах, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх практик ач холбогдолтой юм.

***Түлхүүр үгс:** Компани, хувь нийлүүлсэн хөрөнгө, нэрлэсэн үнэ, татвар, татвар ногдох орлого*

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгийн үндсэн бүрэлдэхүүн .....	5
Хүснэгт 1.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тооцоолох үндсэн томъёо ба тайлагнал .....	7
Хүснэгт 1.3 Хувь нийлүүлсэн хөрөнгийн тооцоолол (жишээ) .....	8
Хүснэгт 1.4 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх үндэслэлүүд.....	8
Хүснэгт 1.5 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх хэлбэрүүд түүний бүртгэл тайлагналын онцлог .....	10
Хүснэгт 1.6 Шинэ хөрөнгө оруулалт татах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үеийн бүртгэл.....	13
Хүснэгт 1.7 Хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар нэрлэсэн үнийг өсгөх үеийн бүртгэл.....	13
Хүснэгт 1.8 Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үеийн татварын эрх зүйн зохицуулалт...	13
Хүснэгт 2.1 “Х” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой журнал бичилт.....	17
Хүснэгт 2.2 Шүүхийн шийдвэрийн тойм.....	18
Хүснэгт 2.3 “Х” ХХК-ийн өөрийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт .....	28
Хүснэгт 2.4 ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт .....	31
Хүснэгт 2.5 Их Британи улсын эрх зүйн зохицуулалт.....	33
Хүснэгт 2.6 Япон улсын эрх зүйн зохицуулалт.....	36

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ****Нэршил товчлол****Тайлбар****ААНОАТгХ**

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль

**КтХ**

Компанийн тухай хууль

**ХНХ**

Хувь нийлүүлсэн хөрөнгө

**НТК**

Нэмж төлөгдсөн капитал

**НББ**

Нягтлан бодох бүртгэл

**НББОУС**

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

**ТЕХ**

Татварын ерөнхий хууль

**ХХОАТгХ**

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

**ХБНГУ**

Холбооны Бүгд Найрамдах Герман улс

**НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР****Нэршил товчлол****Нэмж төлөгдсөн капитал****Хувь нийлүүлсэн хөрөнгө****Хуримтлагдсан ашиг****Хувьцааны нэрлэсэн үнэ****Хувьцааны зах зээлийн үнэ****Тайлбар**

Энгийн хувьцааг борлуулсан үнэ анхны нэрлэсэн үнээс нь давсан хэсгийг

Компанид оруулсан хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг

Компани үүсэн байгуулагдсанаас хойшхи хугацаанд компанид хуримтлагдан үлдсэн ашиг, алдагдлын нийлбэрийг

Компанийн дүрмийн дагуу нэгж хувьцаанд тогтоож өгсөн үнэ

Хувьцааг худалдах болон худалдан авч болох өнөөгийн үнэ

## **ОРШИЛ**

### **Сэдэв сонгосон үндэслэл**

Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх нь орчин үеийн компанийн засаглалын хүрээнд компанийн зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар болон хөрөнгө оруулалт татах стратегийн чухал хэрэгсэл болоод байна. Энэхүү шийдвэр нь зөвхөн техникийн шинжтэй үйлдэл биш бөгөөд компанийн өмчлөлийн бүтэц, хяналтын багцын хуваарилалт болон урт хугацааны санхүүгийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлдэг тул удирдлагын түвшний нарийн тооцоолол, үндэслэл шаарддаг үйл явц юм.

Гэвч практик хэрэгжилтэд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхойгүй байдал үүсгэх, мөн нэрлэсэн үнийн өөрчлөлтөөс үүдэлтэй өөрийн хөрөнгийн бүтцийн дахин ангилал нь татварын тайлагнал болон ногдол ашиг хуваарилалттай холбоотой ээдрээтэй асуудлуудыг бий болгож, улмаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон Хувь хүний орлогын албан татварын ногдуулалтад хэрхэн тусах тал дээр арга зүйн нэгдмэл ойлголт дутагдалтай байгаа нь практикт татварын байгууллага болон татвар төлөгчдийн хооронд маргаан үүсгэх гол шалтгаан болж байна.

Иймд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх үйл явцыг эрх зүйн үндэслэл, нягтлан бодох бүртгэлийн арга зүй болон татварын үр дагаврын үүднээс иж бүрэн шинжлэх нь энэхүү судалгааны ажлын сэдвийг сонгох гол үндэслэл болно.

### **Сэдвийн тулгамдсан байдал**

Өнөөдөр Монголын хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, стратегийн хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх шийдвэрийг түгээмэл гаргах болсон. Гэвч энэхүү стратегийн алхам нь практик дээр эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн арга зүйн зөрүүгээс гадна татварын тодорхойгүй байдал нь маргааныг хамгийн ихээр дагуулж байгаа нь энэхүү сэдвийг судлах гол шаардлага болж байна.

Тухайлбал, хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхөд үүсэх үр дагаврыг өөрийн хөрөнгийн дахин ангилал гэж үзэх эсэх эсхүл хувьцаа эзэмшигчид олгож буй мөнгөн бус ногдол ашиг гэж үзэх эсэх талаар нэгдмэл нэг арга зүй байхгүй байна. Энэхүү тодорхойгүй байдал нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон Хувь хүний орлогын албан татварын ногдуулалтад шууд нөлөөлдөг. Нэрлэсэн үнийн өөрчлөлтөөс үүссэн зөрүүг ногдол ашигтай адилтган үзэж

татвар суутгах нь татвар төлөгч компани болон татварын байгууллагын хооронд үл ойлголцол үүсгэж, улмаар их хэмжээний акт, торгууль тавигдах үндсэн нөхцөл болдог.

Иймд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг татварын бодит маргаантай уялдуулан шинжлэх нь компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад нэн тулгамдсан асуудал болоод байна.

### **Сэдвийн судлагдсан байдал**

Судалгааны сэдвийн суурь болох компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцааны нэрлэсэн үнийн талаарх эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Компанийн эрх зүйн онолын бүтээлүүд болон ном сурах бичгүүдэд хуулийг тайлбарлах зорилгоор системтэйгээр тайлбарласан байна. Түүнчлэн санхүү, нягтлан бодох бүртгэлийн ном сурах бичгүүдэд эздийн өмчийн бүртгэл, түүнтэй холбоотой дансны бичилтийн арга зүйг нарийвчлан тодорхойлсон байдаг. Тус онолын бүтээлүүд, ном сурах бичгүүдэд ерөнхий суурь харилцааг тайлбарласан бөгөөд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудлыг тусгайлан авч үзэж, түүний эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн харилцан хамаарал бүхий үр дагаврыг дэлгэрүүлэн судлаагүй байна.

### **Сэдвийн хамрах хүрээ**

Сэдвийн хүрээнд хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой харилцааг эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн үүднээс дүн шинжилгээ хийнэ. Энэ хүрээнд Улсын дээд шүүхийн шийдвэрт компанийн эрх зүй болон нягтлан бодох бүртгэлийн үр дагаврын дүн шинжилгээ хийж практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, бусад улсын сайн туршлагатай харьцуулан судлахад чиглэнэ.

### **Судалгааны ажлын зорилго**

Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх үйл явцыг эрх зүй болон нягтлан бодох бүртгэлийн хүрээнд иж бүрэн судалж, үүнтэй холбоо бүхий Улсын дээд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж эрх зүйн зохицуулалт болон нягтлан бодох бүртгэлийн хүрээнд үүсэж байгаа асуудалд үр дагаврын дүн шинжилгээ хийхэд энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

### **Судалгааны ажлын зорилт**

- Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, өөрчлөх үндэслэл, төрөл хэлбэрүүд түүний эрх зүйн зохицуулалт болон нягтлан бодох бүртгэлийн тайлагналын онцлогийг тодорхойлох
- Хувьцааны нэрлэсэн үүнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой Улсын дээд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн хувьд үүссэн практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох
- Олон улсын практикт хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх зохицуулалт, хэрэгжилтийг судалж Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулах

### **Судалгааны арга зүй**

Судалгааны ажлын хүрээнд судалгааны онолын хэсэгт, анализ ба синтез, загварчлах болон нэгтгэн дүгнэх, Монгол улсын эх зүйн зохицуулалтын орчныг бусад улсуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулах зорилгоор харьцуулалтын арга мөн судалгааны хэсэгт хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой маргааныг тодорхойлохын тулд Улсын дээд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийв.

### **Судалгааны шинэлэг тал**

Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудлыг зөвхөн онолын хүрээнд бус, эрх зүй, нягтлан бодох бүртгэл болон татварын харилцааны зааг дээрх цогц уялдаа холбоог судалж буй нь уг судалгааны ажлын шинэлэг тал болно. Мөн Улсын дээд шүүхийн шийдвэрт үр дагаврын дүн шинжилгээ хийх замаар компанид үүсэж буй бодит татварын маргааны шалтгаан нөхцөлийг системчлэн судлан гаргаж ирснээрээ онцлогтой.

### **Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол**

Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх үйл явцыг эрх зүй болон нягтлан бодох бүртгэлийн харилцан хамаарал дунд шинжилснээрээ онол болон практикийн дараах ач холбогдолтой юм.

Уг судалгааны ажил нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцийн өөрчлөлтийг онолын түвшинд системчилж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон дотоодын татварын хууль тогтоомжийн хоорондох арга зүйн зөрүүг онол

эрх зүйн үүднээс задлан шинжилж, цаашид компаниудад практикт үүсэж болзошгүй эрх зүйн болон татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ холбогдох хууль тогтоомжийн хийдлийг арилгах, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход өндөр ач холбогдолтой.

## I БҮЛЭГ.ОНОЛЫН ХЭСЭГ

Энэхүү хэсгээр онолын ерөнхий мэдлэг болох хувь нийлүүлсэн хөрөнгө түүнийг өөрчлөх, хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх болон хуримтлагдсан ашиг дансны тухай ойлголтыг авах болно.

### 1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө, түүний бүтэц

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн өөрийн хөрөнгийн хамгийн чухал хэсэг бөгөөд үүсгэн байгуулагчид болон хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдаас тухайн бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр оруулсан хөрөнгийн мөнгөн дүнг хэлнэ. Энэ нь зөвхөн санхүүгийн эх үүсвэр төдийгүй, компанийн хариуцлага хүлээх чадвар, зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах баталгаа болдог<sup>1</sup>.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй”<sup>2</sup> гэж заасан байдаг.

Компанийн эрх зүйн онолын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц нь дараах үндсэн хэсгүүдэд хуваагддаг.<sup>3</sup>

Хүснэгт 1.1 *Хувь нийлүүлсэн хөрөнгийн үндсэн бүрэлдэхүүн*

Хувь нийлүүлсэн хөрөнгө		
Бүрэлдэхүүн хэсэг	Тайлбар	
Гаргасан хувьцаа	Зарласан хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг эргэлтэд гаргасан хувьцаа гэнэ. <sup>4</sup> Өөрөөр хэлбэл бодитоор зах зээлд гаргаж, хөрөнгө оруулагчдын эзэмшилд шилжүүлсэн хувьцааг хэлнэ.	
	Давуу эрхийн хувьцаа	Энгийн хувьцаа

<sup>1</sup> Richard A. Brealey, Stewart C. Myers and Franklin Allen, *Principles of Corporate Finance*, (New York: McGraw-Hill Education, 2020), 384 дэх тал.

<sup>2</sup> Монгол Улсын Компанийн тухай хууль (2011)-ийн 30 дугаар зүйлийн 30.1 “Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй”

<sup>3</sup> Andreas Cahn and David C. Donald, *Comparative Company Law: Text and Cases on the Laws Governing Corporations in Germany, the UK and the USA*, 2nd ed. (Cambridge University Press, 2018)

<sup>4</sup> Монгол Улсын Компанийн тухай хууль (2011)-ийн 33 дугаар зүйлийн 33.2 “Зарласан хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг эргэлтэд гаргасан хувьцаа гэнэ”

	<p>Давуу эрхтэй хувьцаа нь саналын эрхгүй боловч энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж тогтмол хэмжээний ашиг хүртэх боломжийг олгодог. Мөн давуу эрхтэй хувьцаа эзэмшигч нь компани татан буугдах нөхцөлд энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж өөрт ногдох хөрөнгөө гаргуулж авах зэрэг эрхийг эдэлнэ.</p>	<p>Тухайн компанийн өмчлөлийн тодорхой хэсгийг гэрчлэх үнэт цаасны нэг төрөл юм. Энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, санал өгөх, компанийн ашгаас хувь хүртэх эрхийг эдэлнэ.</p>
<p>Нэмж төлөгдсөн капитал</p>	<p>Компанийн гаргасан энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааны зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс нь илүү байвал зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд хуримтлуулан бүртгэдэг.<sup>5</sup></p> <p>Хувьцааны нэрлэсэн үнэ зах зээлийн үнээс өндөр байгаа үед нэмж төлөгдсөн капитал данс нь сөрөг тохируулах данс болно.</p>	
<p>Халаасны хувьцаа</p>	<p>Компани гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан халаасны хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна. Халаасны хувьцаа нь гаргасан хувьцааны тоонд орж тооцогдох боловч эргэлтэд байгаа хувьцааны тоонд орохгүй.</p>	

Дээрх хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцийн дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тооцоолохдоо нь дараах томъёог ашигладаг.

<sup>5</sup> Жамсранжавын Нямсүрэн, Санхүүгийн бүртгэл-II, (Улаанбаатар: Соёмбо пресс, 2018), 302 дахь тал.

## Хүснэгт 1.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тооцоолох үндсэн томъёо ба тайлагнал

Бүрэлдэхүүн хэсэг	Тооцоолох томъёо	Тайлан балансад тусах хэлбэр, хуулийн зүйл заалт
Гаргасан хувьцаа	<u>Энгийн хувьцаа</u> Энгийн хувьцааны тоо, ширхэг × Нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ $N_{common} \times P_{nominal}$	Нэмэх (+): Өөрийн хөрөнгө  <i>KmX-ийн 33.2</i>
	<u>Давуу эрхийн хувьцаа</u> Давуу эрхийн хувьцааны тоо, ширхэг × Нэгж давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнэ $N_{pref} \times P_{nominal}$	Нэмэх (+): Өөрийн хөрөнгө  <i>KmX-ийн 33.2</i>
Нэмж төлөгдсөн капитал (НТК)	Хувьцааны тоо, ширхэг × (Нэгж хувьцааны зах зээлийн үнэ – Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ)  $N \times (P_{market} - P_{nominal})$	Нэмэх (+): Өөрийн хөрөнгө
Халаасны хувьцаа	Буцаан авсан хувьцааны тоо, ширхэг × Нэгж хувьцааны үнэ  $N_{repurchased} \times P_{purchase}$	Хасах (-): Өөрийн хөрөнгө  <i>KmX-ийн 49.3</i>
Цэвэр хувь нийлүүлсэн хөрөнгө	(Энгийн хувьцаа + Давуу эрхийн хувьцаа + Нэмж төлөгдсөн капитал) – Халаасны хувьцаа  $\sum(Common + Pref + APIC) - Treasury$	Нийт дүн  <i>KmX-ийн 30.1</i>

Дээрх хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, томъёоллыг ойлгомжтой байх үүднээс дараах жишээгээр тайлбарлавал, “А” компани нь энгийн болон давуу эрхийн хувьцаа гаргасан бөгөөд нэгж энгийн хувьцаа бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй. Тус компани 10,000 ширхэг энгийн хувьцааг зах зээлд нэг бүрийг нь 550 төгрөгөөр худалджээ. Ингэснээр хувьцааны нэрлэсэн үнийн дүн болох 1,000,000 төгрөг нь энгийн хувьцаа дансанд, харин нэрлэсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүү буюу нэгж хувьцаа бүрээс үүссэн 450 төгрөг, нийт 4,500,000 төгрөг нь нэмж төлөгдсөн капитал дансанд тус тус

бүртгэгдэнэ. Үүнээс гадна тус компани нэг бүр нь 500 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000 ширхэг давуу эрхийн хувьцаа гаргасан 500,000 төгрөг давуу эрхийн хувьцаа дансанд бүртгэгдэнэ. Компани өөрийн гаргасан хувьцаанаас 200,000 төгрөгийн дүнтэй хувьцааг зах зээлээс эргүүлэн худалдаж авсан бөгөөд үүнийг халаасны хувьцаа гэж үзэж нийт хувь нийлүүлсэн хөрөнгөөс хасаж тооцно. Ийнхүү эцсийн дүнгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,800,000 төгрөг болж байна.

Хүснэгт 1.3 *Хувь нийлүүлсэн хөрөнгийн тооцоолол (жишээ)*

	Тооцоолол	Дүн (₮)
Энгийн хувьцаа	100₮ x 10,000 ширхэг	1,000,000₮
Нэмж төлөгдсөн капитал – Энгийн хувьцаа	(550₮ - 100₮) x 10,000 ширхэг	4,500,000₮
Давуу эрхийн хувьцаа	500₮ x 1,000 ширхэг	500,000₮
Хасах нь: Халаасны хувьцаа	(Эргүүлэн авсан)	(200,000₮)
Хувь нийлүүлсэн хөрөнгө		5,800,000₮

## 1.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийг хэмжээг өөрчлөх үндэслэл, түүний хэлбэр, бүртгэл тайлагналын онцлог

Компанийн эрх зүйн онолд хувь нийлүүлсэн хөрөнгө нь гуравдагч этгээдтэй харилцах итгэлцлийн суурь болдог<sup>6</sup> бөгөөд компанийн үйл ажиллагааны цар хүрээ, зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлага тулгарч улмаар тухайн компанийн санхүүгийн болон стратегийн зорилгоос хамааран хувь нийлүүлсэн хөрөнгийг хэмжээг нэмэгдүүлэх эсвэл бууруулах шийдвэр гаргадаг.

Хүснэгт 1.4 *Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх үндэслэлүүд*

ХНХ-г өөрчлөх чиглэл	ХНХ-ийг хэмжээг өөрчлөх үндэслэл шалтгаан нөхцөл <sup>7</sup>
Нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ төсөл хэрэгжүүлэх, урт хугацааны хөрөнгө оруулалт хийхэд нэмэлт санхүүжилт татах. Энэ тохиолдолд шинэ хувьцаа гаргах замаар өмчийн санхүүжилт босгох нь</li> </ul>

<sup>6</sup> Paul L. Davies and Sarah Worthington, *Gower's Principles of Modern Company Law, 11th ed.* (London: Sweet & Maxwell, 2021), 571 дэх тал.

<sup>7</sup> Мөн тэнд 573-580 дахь тал.

	<p>өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байх давуу талтай гэж үздэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Компанийн санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах, өр ба өмчийн санхүүжилтийн харьцааг тэнцвэржүүлэх. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх нь компанийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг сайжруулж, зээлдэгчдийн итгэлийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй.</li> <li>• Хууль тогтоомжид заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод шаардлагыг хангах, эсхүл тодорхой зөвшөөрөл, лиценз авахтай холбоотойгоор хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүсэх.</li> <li>• Хуримтлагдсан алдагдлын улмаас өөрийн хөрөнгийг сэргээх, санхүүгийн тайлангийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх.</li> </ul>
Бууруулах	<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн үйл ажиллагаанд шаардлагагүй илүүдэл капитал үүссэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдэд буцаан олгож, капиталын үр ашиггүй байдлыг арилгах. Санхүүгийн онолд илүүдэл капитал нь компанийн өгөөжийг бууруулдаг гэж үздэг.</li> <li>• Компанийн капиталын бүтцийг оновчлох, өмчийн санхүүжилтийн хэмжээг багасгаж, өрийн санхүүжилтийн зохистой түвшинд хүргэх стратегийн зорилгыг хэрэгжүүлэх буюу капиталын бүтцийн тус өөрчлөлт нь капиталын дундаж өртгийг бууруулах боломжтой.</li> <li>• Компанийн үйл ажиллагааны цар хүрээ багассан, зах зээлийн нөхцөл өөрчлөгдсөнтэй уялдуулан анхны хөрөнгийн хэмжээ бодит хэрэгцээнээс давсан нөхцөл бий болсон.</li> </ul>

Дээр дурдсанчлан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх эсхүл бууруулах нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхолд шууд нөлөөлөх эрх зүйн ач холбогдол бүхий үйл ажиллагаа юм. Иймд Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-г заасан дараах хэлбэрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчилдөг бөгөөд түүний эрх зүйн зохицуулалт, бүртгэл тайлагналын онцлогтой уялдуулан тайлбарлавал, Хүснэгт 1.5 *Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх хэлбэрүүд түүний бүртгэл тайлагналын онцлог*

ХНХ-ийн хэмжээг өөрчлөх хэлбэр	Эрх зүйн зохицуулалт	Бүртгэл тайлагналын онцлог /НББ болон татварын нөлөө/
Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх <sup>8</sup>	КтХ-ийн 31.2.1.Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар ХНХ-г нэмэгдүүлнэ.	<p>Нэгдүгээрт, хувьцаа эзэмшигч зөрүү төлбөрийг төлөх тохиолдолд хувьцаа эзэмшигч өсгөх үеийн зөрүү төлбөрийг мөнгөн хөрөнгөөр төлнө.<sup>9</sup></p> <p>Энэхүү хувьцаа эзэмшигчийн оруулж буй мөнгөн хөрөнгө нь компанийн үйл ажиллагааны орлого биш, харин эзэмшигчдийн оруулж буй хувь нийлүүлсэн хөрөнгө юм. Иймд ААНОАТтХ-иар дүрмийн санг нэмэгдүүлж буй хөрөнгө оруулалтыг татвар ногдох орлогод тооцдоггүй.</p> <p>Хоёрдугаарт, өөрийн хөрөнгийн бусад данс /хуримтлагдсан ашиг, НТК/-аас ХНХ-г нэмэгдүүлэх тохиолдолд гаднаас мөнгөн хөрөнгө орж ирэхгүйгээр өөрийн хөрөнгийн данс хооронд шилжилт хийх<sup>10</sup> буюу хуримтлагдсан ашиг данс</p>

<sup>8</sup> Монгол Улсын Компанийн тухай хууль (2011)-ийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 “нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах”

<sup>9</sup> Reinier Kraakman et al., *The Anatomy of Corporate Law: A Comparative and Functional Approach*, 3rd ed. (Oxford: Oxford University Press, 2017), 188-197 дахь тал.

<sup>10</sup> *Мөн тэнд* 188-197 дахь тал.

		<p>буурч, холбогдох хувьцааны данс нэмэгдэнэ.</p> <p>Хэрэв татварын алба үүнийг хувьцаа эзэмшигчид бэлэн бусаар ногдол ашиг өгч буй хэлбэр буюу ААНОАТТХ-ийн 9.1.3,<sup>11</sup> 9.3<sup>12</sup>-г заасан ногдол ашгийн орлого гэж үзсэн тохиолдолд ААНОАТТХ-ийн 20.2.1<sup>13</sup>-г зааснаар 10 хувийн ногдуулна.</p> <p>Хувьцаа эзэмшигч уг зөрүүгээс бэлэн болон бэлэн бус хэлбэрээр ашиг хүртвэл ХХОАТТХ-ийн 9.1.3<sup>14</sup>, 21.2.4<sup>15</sup>-г зааснаар 10 хувийн ногдол ашгийн татвар төлнө.</p>
Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах <sup>16</sup>	КтХ-ийн 31.2.1.Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар ХНХ-г бууруулна.	Энэ тохиолдолд хувьцааны нэрлэсэн үнийн бууралтын зөрүүгээр холбогдох хувьцааны дансыг дебетэлж (бууруулж), хуримтлагдсан ашиг дансыг кредитлэх (өсгөх) журнал бичилт хийгдэнэ.
Хувьцаа нэмж гаргах <sup>17</sup>	КтХ-ийн 31.2.2.Хувьцаа нэмж гаргах замаар ХНХ-г нэмэгдүүлнэ.	Компанид мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө орж ирэх тул нийт актив (хөрөнгө) болон холбогдох хувьцааны данс нэмэгдэнэ.

<sup>11</sup> Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2019)-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 “ногдол ашгийн орлого”

<sup>12</sup> Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2019)-ийн 9 дүгээр зүйлийн 9.3 “Энэ хуулийн 9.1.3-т заасан ногдол ашгийн орлогод хувьцаа эзэмшил, нөхөрлөлийн буюу хамтран ажиллах гэрээнээс олсон мөнгөн болон мөнгөн бус орлого, ашгийн хувь, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг гэж үзэх бусад орлого хамаарна”

<sup>13</sup> Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2019)-ийн 20 дугаар зүйлийн 20.2.1 “энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.7, 18.7-д заасан орлогод 10 хувиар”

<sup>14</sup> Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2019)-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 “ногдол ашгийн орлого”

<sup>15</sup> Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2019)-ийн 21 дүгээр зүйлийн 21.2.4 “энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар”

<sup>16</sup> Монгол Улсын Компанийн тухай хууль (2011)-ийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 “нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах”

<sup>17</sup> Монгол Улсын Компанийн тухай хууль (2011)-ийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 “хувьцаа нэмж гаргах замаар өсгөх”

		Шинэ хөрөнгө оруулалт татах буюу хувьцаа нэмж гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж буй тохиолдолд ААНОАТХ-д зааснаар татвар ногдохгүй.
Өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авах <sup>18</sup>	КтХ-ийн 31.2.3.Өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар ХНХ-г бууруулна.	Эргүүлэн худалдан авсан хувьцааны нэрлэсэн дүнгээр холбогдох хувьцааны дансыг дебетэлж (бууруулж), мөнгөн хөрөнгийн дансыг кредитэлж (бууруулж) холбогдох журнал бичилтийг хийнэ.

### 1.3 Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үеийн нягтлан бодох бүртгэлийн арга зүй, эрх зүйн зохицуулалт

Өмнөх хэсэгт дурдсанчлан Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31.2.1-т зааснаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлдэг. Энэхүү хэлбэр нь нягтлан бодох бүртгэлийн арга зүйн хувьд дараах хоёр байдлаар хэрэгжих боломжтой гэж үздэг. Үүнд,

#### 1. Шинэ хөрөнгө оруулалт татах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх

Энэхүү аргын хүрээнд компанид мөнгөн хөрөнгө, эсхүл биет болон биет бус хөрөнгийг бодитойгоор хөрөнгө оруулж, үүний үндсэн дээр нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлдэг.<sup>19</sup> Энэ тохиолдолд компанийн актив (хөрөнгө) болон эздийн өмчийн нийт дүн зэрэг өсдөг онцлогтой. Нягтлан бодох бүртгэлийн журнал бичилтийн хувьд мөнгөн хөрөнгө эсхүл холбогдох хөрөнгийн данс дебетлэгдэж (өсөж), энгийн хувьцааны данс кредитлэгдэнэ (өснө).

Хүснэгт 1.6 *Шинэ хөрөнгө оруулалт татах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үеийн бүртгэл*

Дб	Холбогдох хөрөнгийн данс	xxx	
Кр	Энгийн хувьцаа		xxx

<sup>18</sup> Монгол Улсын Компанийн тухай хууль (2011)-ийн 31 дүгээр зүйлийн 31.2.3 “*өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах*”

<sup>19</sup> Reinier Kraakman et al., *The Anatomy of Corporate Law: A Comparative and Functional Approach*, 3rd ed. (Oxford: Oxford University Press, 2017), 188-197 дахь тал.

## 2. Хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар нэрлэсэн үнийг өсгөх

Компанийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хуримтлагдсан ашгийн тодорхой хэсгийг хувь нийлүүлсэн хөрөнгө рүү шилжүүлэх замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөж болно.<sup>20</sup> Энэ тохиолдолд компанийн нийт эздийн өмч (өөрийн хөрөнгө)-ийн хэмжээ өөрчлөгдөхгүй бөгөөд зөвхөн эздийн өмч (өөрийн хөрөнгө)-ийн бүтцэд дотоод шилжилт хийгддэг. Бүртгэлийн хувьд хуримтлагдсан ашиг данс дебетлэгдэж (буурч), энгийн хувьцаа данс кредитлэгддэг (өсдөг).

Хүснэгт 1.7 *Хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар нэрлэсэн үнийг өсгөх үеийн бүртгэл*

Дб	Хуримтлагдсан ашиг	xxx	
Кр	Энгийн хувьцаа		xxx

Дээрх нягтлан бодох бүртгэлийн аргачлалууд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хиймлээр өсгөхөөс сэргийлж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдлыг хангах суурь нөхцөл болдог. Ийнхүү дээрх хоёр арга замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд татварын эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлэн тайлбарлавал,

Хүснэгт 1.8 *Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үеийн татварын эрх зүйн зохицуулалт*

Хэлбэр	Холбогдох хуулийн зүйл, заалт
Шинэ хөрөнгө оруулалт татах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж буй гаднаас орж ирэх хөрөнгө оруулалт нь ААНОАТтХ-д зааснаар компанийн татвар ногдох орлогод тооцогдохгүй.
Хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар нэрлэсэн үнийг өсгөх	<ul style="list-style-type: none"> <li>ААНОАТтХ-ийн хүрээнд, 9.1.3.ногдол ашгийн орлого; 9.3.Энэ хуулийн 9.1.3-т заасан ногдол ашгийн орлогод хувьцаа эзэмшил, нөхөрлөлийн буюу хамтран ажиллах гэрээнээс олсон мөнгөн болон мөнгөн бус орлого, ашгийн хувь, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг гэж үзэх бусад орлого хамаарна.</li> </ul>

<sup>20</sup> Мөн тэнд 188-197 дахь тал.

	<p>18.6. Дараах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдох тухайн орлогын төрөл тус бүрийн нийт дүнгээр тооцно:</p> <p>18.6.2. ногдол ашгийн орлого;</p> <p>20.2.1. энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.7, 18.7-д заасан орлогод 10 хувиар;</p> <p>24.1. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.4, 18.6.5, 18.6.7, 18.6.8-д заасан орлогод ногдох албан татварыг суутган төлөгч ногдуулж, суутгана.</p> <ul style="list-style-type: none"><li>• ХХОАТХ-ийн хүрээнд,</li></ul> <p>9.1.3. ногдол ашгийн орлого;</p> <p>9.3. Ногдол ашгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.3-т заасныг хамааруулна.</p> <p>16.1. Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:</p> <p>16.1.3. ногдол ашгийн орлогыг нийт дүнгээр;</p> <p>21.2.4. энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар;</p> <p>26.1. Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө:</p> <p>26.1.2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-т тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;</p>
--	---

**Бүлгийн дүгнэлт:**

Энэхүү бүлгийн хүрээнд компанийн өөрийн хөрөнгийн гол бүрэлдэхүүн хэсэг болох хувь нийлүүлсэн хөрөнгийн тухай ойлголт, бүтэц, түүнийг өөрчлөх эрх зүйн зохицуулалтыг системтэйгээр авч үзлээ. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй” хэмээн хуульчилсан бөгөөд хувьцааны зах зээлийн үнэ болон нэрлэсэн үнийн зөрүүгээс үүсэх нэмж төлөгдсөн капиталын талаар хуульчлан зохицуулаагүй байна.

Түүнчлэн, хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх явцад татварын эрх зүйн хувьд гаднаас шинэ хөрөнгө оруулалт татах тохиолдолд татвар ногдох орлогод тооцогддоггүй бол, компанийн өөрийн хөрөнгө болох хуримтлагдсан ашгаас ашгийг капиталжуулах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх явцад бэлэн бус хэлбэрээр ногдол ашиг хуваарилсантай адилтган үзэж, холбогдох татварын хууль тогтоомжийн дагуу 10 хувийн татвар ногдуулах үндэслэл болдог. Үүнээс үзэхэд компанийн санхүүгийн бүртгэл болон эрх зүйн зохицуулалт нь хоорондоо салшгүй уялдаа холбоотой, нэг нэгнийгээ нөхөж байдаг суурь ойлголт юм.

## II БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү судалгааны хэсэгт хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ тус шүүхийн шийдвэрт үүссэн маргаантай асуудалд эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн үр дагаврыг шинжлэн судалсан болно. Мөн Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 дэх заалтыг ХБНГУ, Их Британи, Япон зэрэг улсуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судаллаа.

### **2.1 Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой шүүхийн шийдвэр хууль хэрэглээний үр дагаврын шинжилгээ**

Шүүхийн шийдвэрийн нэгдсэн санд хийсэн хайлтаар Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 дэх заалтын хүрээнд буюу хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн 001/ХТ2024/0084 дугаар бүхий нэг шүүхийн шийдвэр<sup>21</sup> байна. Иймд уг шүүхийн шийдвэрийг сонгон авч, эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн үр дагаврын дүн шинжилгээ хийх замаар хууль хэрэглээний асуудлыг тодорхойлохыг зорилоо.

#### **Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн үйл баримтын тухайд**

Татварын ерөнхий газраас “Х” ХХК-ийн 2012-2016 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг шалгаж, 8,093,019,484 төгрөгийн төлбөр тогтоосон байх бөгөөд хэргийн оролцогчид тооцооллын хувьд маргаангүй, харин хууль хэрэглээний хувьд тогтоосон төлбөрийг төлөх эсэхэд маргасан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэнтэй холбоотой үйл баримтыг дэлгэрүүлэн тайлбарлавал,

“Х” ХХК нь банкны тусгайлсан зохицуулалтын хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум болгож өсгөх үүрэг хүлээжээ. Тус үүргийн хүрээнд “Х” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 7 дугаар тогтоолоор нэгж энгийн хувьцааны үнийг 5000 төгрөгөөс 8000 төгрөг болгож өсгөхийг зөвшөөрч, ийнхүү энгийн хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ мөнгөн хөрөнгөөр бус, өөрийн хөрөнгийн нөөцийн

---

<sup>21</sup> Улсын дээд шүүхийн 2024 оны 09 сарын 23-ны өдрийн 001/ХТ2024/0084 тогтоол, [https://shuukh.mn/single\\_case/3282?daterange=2024-09-01%20-%202024-09-30&id=3&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/3282?daterange=2024-09-01%20-%202024-09-30&id=3&court_cat=3&bb=1)

сан буюу хуримтлагдсан ашиг данснаас 5,656,094,961.41 төгрөг, нэмж төлөгдсөн капитал данснаас 14,140,923,038.59 төгрөг, нийт 19,797,018,000,000 төгрөгийг энгийн хувьцаа дансанд шилжүүлж дараах ажил гүйлгээг хийж хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлжээ.

Хүснэгт 2.1 “Х” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой журнал бичилт

Дб	Хуримтлагдсан ашиг	5,656,094,961.41 ₮	
Дб	Нэмж төлөгдсөн капитал	14,140,923,038.59 ₮	
Кр	Энгийн хувьцаа		19,797,018,000,000 ₮

Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, аргазүйн газрын болон Улсын төсвийн орлого хяналтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч нар Х ХХК-ийн 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт явуулж 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн ..... дугаар шийтгэлийн хуудсаар “Х” ХХК-г ногдол ашиг хувь нийлүүлэгч нарт олгохдоо суутган төлөгчийн үүрэг биелүүлээгүй хэмээн үзэж 17,209,782,000 төгрөгийн зөрчилд, нөхөн төлбөр 2,753,565,300, торгууль 826,069,690, алданги 550,713,060 төгрөгийн шийтгэл оногдуулсан.

Гэвч “Х” ХХК-иас “Банкны тусгайлсан зохицуулалтын хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум болгож өсгөх үүрэг хүлээж, энгийн хувьцааны нэрлэсэн үнийг 5000 төгрөгөөс 8000 төгрөг болгон өсгөсөн. Энэ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 32.9 тэрбум байснаас 50 тэрбум болгож нэмэгдүүлсэн болохоос ногдол ашиг хуваарилаагүй, ногдол ашгийг хувьцаанд хөрвүүлнэ гэдэг нь тухайн хүнд тодорхой тооны хувьцаа нэмж хөрвүүлэх тухай ойлголт” хэмээн маргажээ.

### **Тус маргааныг шийдвэрлэсэн бүх шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлийн тухайд**

Энэхүү маргаан нь Монгол Улсын шүүхийн бүх шатны шүүхээр 2020 оноос 2024 он хүртэл нийт 4 жилийн турш дамжсан, процессын хувьд маш ээдрээтэй, хууль зүйн ач холбогдол бүхий томоохон хэрэг юм. Шүүхийн шийдвэрийн үндэслэл, хууль хэрэглээний тайлбарын хамт доор нэгтгэн харууллаа.

## Хүснэгт 2.2 Шүүхийн шийдвэрийн тойм

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх <sup>22</sup> /2020 оны 12 сарын 22/	
Шүүхийн шийдэл	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэрээр маргаан бүхий захиргааны актыг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж, захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргахыг даалгаж шийдвэрлэсэн байна.
Үндэслэсэн хуулийн заалт	<p>ААНОАТХ-ийн 9.3. Энэ хуулийн 9.1.3-д заасан ногдол ашгийн орлогод хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжээс ашиг хуваах, хувь хүртэх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого, түүний хүү хамаарна.</p> <p>КтХ 46.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл/ байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.</p>
Хууль хэрэглээ тайлбар	Хэрэгт авагдсан нотлох баримтууд болон Монголбанкны 2015, 2020 оны албан бичгүүдээс үзэхэд "Х" ХХК нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 5000 төгрөгөөс 8000 төгрөг болгон өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах үйл ажиллагааны шинжийг агуулаагүй. Үүнийг ногдол ашиг хуваарилсан гэж үзэх нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтын агуулгад нийцэхгүй юм. Иймд захиргааны байгууллага нь компанийн өөрийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлтийг ногдол ашиг олгосон гэж тайлбарлан татвар ногдуулсан нь ойлгомжгүй, татвар ногдуулах зорилгодоо нийцээгүй гэж тайлбарласан байна.

<sup>22</sup> Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 12 сарын 22-ны өдрийн 128/ШШ2020/0817 шийдвэр, [https://shuukh.mn/single\\_case/9793?start\\_date=&end\\_date=&id=1&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/9793?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1)

<b>Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх<sup>23</sup> /2021 оны 03 сарын 24/</b>	
Шүүхийн шийдэл	Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн магадлалаар анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.
Шүүхийн шийдлийн үндэслэл	Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийг хэргийн үйл баримтад бүрэн дүүрэн хууль зүйн дүгнэлт хийгээгүй гэж үзэв. Тодруулбал, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн үйлдэл нь ногдол ашгийн орлогод хамаарахгүй, татвар ногдох үндэслэл болохгүй гэж дүгнэхдээ хувьцаа эзэмшигчдийн хэзээ гаргасан ямар шийдвэрээр, нэгж хувьцааны үнийг хэрхэн өсгөсөн, уг өөрчлөлт нь хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ямар байдлаар холбогдсон зэрэгт нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай. Ялангуяа 17,209,782,000.0 төгрөгт албан татвар ногдуулж төсөвт төлөөгүй гэх татварын зөрчил нь “өөрийн хөрөнгө”-өө нэмэгдүүлсэн үү, эсхүл “хувь нийлүүлсэн хөрөнгө”-өө нэмэгдүүлсэн үү гэдгийг ялгаж салган хууль зүйн дүгнэлт хийх шаардлагатай хэмээн үзсэн байна.
<b>Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх<sup>24</sup> /2022 оны 05 сарын 09/</b>	
Шүүхийн шийдэл	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн шийдвэрээр татварын улсын байцаагчийн гаргасан шийтгэлийн хуудсыг хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнэж, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.
Үндэслэсэн хуулийн заалт	БтХ-ийн 35.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт,

<sup>23</sup> Нийслэл дэх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 03 сарын 24-ний өдрийн 221/МА2021/0153 магадлал,

[https://shuukh.mn/single\\_case/4090?start\\_date=&end\\_date=&id=2&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/4090?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1)

<sup>24</sup> Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхийн 2022 оны 05 сарын 09-ний өдрийн 128/ШШ2022/0358 шийдвэр, [https://shuukh.mn/single\\_case/10039?start\\_date=&end\\_date=&id=1&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/10039?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1)

	<p>банкны төлбөрийн чадвар, банкны систем дэх нөлөө, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк тогтооно.</p> <p>ААНОАТХ-ийн 9.3. 9.1.3-д заасан ногдол ашгийн орлогод хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжээс ашиг хуваах, хувь хүртэх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого, түүний хүү хамаарна.</p> <p>ААНОАТХ-ийн 9.1.3. Ногдол ашгийн орлогод албан татвар ногдоно,</p> <p>ААНОАТХ-ийн 16.3.1. Ногдол ашгийн орлогод нийт дүнгээр тооцохоор,</p> <p>ААНОАТХ-ийн 17.2.1. Ногдол ашгийн орлогод 10 хувиар,</p> <p>ААНОАТХ-ийн 17.2.9. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон дараах орлогод 20 хувиар, а. Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлогод</p> <p>ААНОАТХ-ийн 21.5. Энэ хуулийн 17.2.1, 17.2.9-д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.</p>
Хууль хэрэглээ тайлбар	<p>Шүүхээс хэргийг дахин хянан хэлэлцээд "Х" ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн үйлдлийг ногдол ашиг хуваарилсан гэж үзэх үндэслэлтэй хэмээн дүгнэжээ. Хэдийгээр Монголбанкны зүгээс банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх шаардлага тавьж, тодорхой хугацаанд ногдол ашиг гаргахгүй байх чиглэл өгсөн ч энэ нь татвараас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж үзэв. Учир нь Монголбанк нь Компанийн тухай хуульд заасан ногдол ашиг мөн эсэхийг тодорхойлох, түүнд татвар ногдуулах эсэхийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага биш бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэлэмжийг өсгөж байгаа нь ААНОАТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасан “мөнгөн бус</p>

	орлого” буюу ашиг хуваах хэлбэрт хамаарч байна. Иймд 17,209,782,000.00 төгрөгийн ногдол ашгийн орлогод хуульд заасан хувь хэмжээгээр татвар ногдуулж, төсөвт суутган шилжүүлээгүй нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд татвар ногдуулсан улсын байцаагчийн шийдвэр үндэслэлтэй гэж үзсэн байна.
<b>Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх<sup>25</sup> /2022 оны 07 сарын 20/</b>	
Шүүхийн шийдэл	Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн байна.
Шүүхийн шийдлийн үндэслэл	Давж заалдах шатны шүүхээс хэргийг хянан үзээд, анхан шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалд дурдсан ажиллагааг хийгээгүй. Тодруулбал, өмнө нь тогтоогдсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын зөрчил арилаагүй, зөрүүтэй нөхцөл байдлын талаар тодруулаагүй, нотлох үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж маргаан бүхий шийтгэлийн хуудас, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл тус бүрд дүгнэлт өгөөгүй. Иймд давж заалдах шатны шүүх нөхөн гүйцэтгэж, хэргийг эцэслэн шийдвэрлэх эрх зүйн боломжгүй тул шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаах нь зүйтэй гэж үзжээ.
<b>Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх<sup>26</sup> /2024 оны 01 сарын 03/</b>	
Шүүхийн шийдэл	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн шийдвэрээр, татварын улсын байцаагч нар торгууль, алданги тооцсон нь үндэслэлгүй гэж үзэж, шийтгэлийн хуудсын Нэг-ийн 1 дэх хэсэгт тоосон төлбөрөөс

<sup>25</sup> Нийслэл дэх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 07 сарын 20-ны өдрийн 221/МА2022/0500 магадлал,

[https://shuukh.mn/single\\_case/5160?start\\_date=&end\\_date=&id=2&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/5160?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1)

<sup>26</sup> Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхийн 2024 оны 01 сарын 03-ны өдрийн 128/ШШ2024/0021 шийдвэр, [https://shuukh.mn/single\\_case/15410?daterange=2024-01-01%20-%202024-01-03&id=1&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/15410?daterange=2024-01-01%20-%202024-01-03&id=1&court_cat=3&bb=1)

	826,069,590.00 төгрөгийн торгууль, 550,713,060.00 төгрөгийн алданги, нийт 1,376,782,650 төгрөгийг хасаж багасгахаар шийдвэрлэв.
Үндэслэсэн хуулийн заалт	<p>ГЕХ /2008 он/ 18.1.6. Бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тоосон хугацаанд төсөвт төлөх</p> <p>ХХОАТТХ /2006 он/ 5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.</p> <p>ХХОАТТХ /2006 он/ 8.1. Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараахь орлогод албан татвар ногдуулна: 8.1.3.хөрөнгийн орлого</p> <p>ХХОАТТХ /2006 он/ 13.1. Хөрөнгийн орлогод дараахь орлого хамаарна: 13.1.3.ногдол ашгийн орлого,</p> <p>ХХОАТТХ /2006 он/ 19.1.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно: 19.1.3.ногдол ашгийн орлогыг дүнгээр нь;</p> <p>ХХОАТТХ /2006 он/ 23.1. Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл,...зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татварын ногдуулна.</p> <p>ААНОАТТХ /2006 он/ 9.1.Албан татвар төлөгчийн хөрөнгийн дараахь орлогод албан татвар ногдоно: 9.1.3.ногдол ашгийн орлого;</p> <p>ААНОАТТХ /2006 он/ 17.2.Албан татвар төлөгчийн дараахь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна: 17.2.9. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон дараахь орлогод 20 хувиар,</p>

	<p>ААНОАТгХ /2006 он/ 21.5. Энэ хуулийн 17.2.7-17.2.9-д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч ... төсөвт шилжүүлнэ.</p> <p>зөрчилд торгууль, алданги ногдуулсан тухайд.</p> <p>ТЕХ /2008 он/ 4.1.6. Татвар суутгагч гэж татвар төлөгчийн олсон орлогод татварын хуулиар татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг</p> <p>ТЕХ /2008 он/ 29.1. Татварын улсын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: гээд 29.1.5-д татвар суутгагч хувь хүн, хуулийн этгээд нь бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод татвар ногдуулж, суутган авч төсөвт төлөөгүй бол түүнийг уг этгээдийн хөрөнгөөс нөхөн төлүүлэх;</p> <p>ТЕХ /2008 он/ 74.1. Дараах үйлдэл, эс үйлдэхүйгээр татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль оногдуулна.</p>
<p>Хууль хэрэглээ тайлбар</p>	<p>Шүүхээс хэргийн үйл баримтыг дүгнэхдээ Х банк ХХК нь компанийн хуримтлагдсан ашгаас бүрдсэн “нөөцийн сан” болон “нэмж төлөгдсөн капитал” данснаас хөрөнгө гаргаж, хувьцааны нэрлэсэн үнийг 5000-8000 төгрөг болгон өсгөсөн нь хувьцаа эзэмшигчид мөнгөн бус хэлбэрээр ногдол ашиг хүртсэн үйлдэл мөн гэж үзсэн. Учир нь тус гүйлгээний үр дүнд компанийн өөрийн хөрөнгө буурч, хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө харгалзах дүнгээр өссөн нь татварын хуульд заасан “ногдол ашгийн орлого” гэх ойлголтод шууд хамаарч байна. Иймд банкныг суутган төлөх үүргээ биелүүлээгүй гэж үзэж, нөхөн татвар ногдуулсан нь үндэслэлтэй юм.</p> <p>Торгууль, алданги ногдуулсан тухайд, Татварын ерөнхий хуулийн (2008 он) дагуу Х банк ХХК нь татвар төлөгч бус, харин бусдын олсон орлогод татвар ногдуулах “татвар суутгагч”-ийн үүрэгтэй оролцсон бөгөөд хуульд зааснаар татвар суутгагч</p>

	<p>татварыг суутган авч төлөөгүй тохиолдолд татварын байцаагч уг татварыг суутгагчийн хөрөнгөөс зөвхөн нөхөн төлүүлэх бүрэн эрхтэй бөгөөд суутгагчид татвар нуусан этгээдэд хүлээлгэдэг торгууль, алдангийг давхар ногдуулах нь хууль зүйн үндэслэлгүй гэж дүгнэн, торгууль болон алдангийн хэсгийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.</p>
<p><b>Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх<sup>27</sup> /2024 оны 05 сарын 28/</b></p>	
<p>Шүүхийн шийдэл</p>	<p>Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, хариуцагч нарын гомдлыг хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн байна. Ингэхдээ шийтгэлийн хуудсаар ногдуулсан төлбөрөөс 826,069,590.00 төгрөгийн торгуулийг хасаж, харин 550,713,060.00 төгрөгийн алдангийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.</p>
<p>Шүүхийн шийдлийн үндэслэл</p>	<p>Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн ногдол ашгийн орлого олсон гэх дүгнэлтийг зөв гэж үзсэн боловч зарим санхүүгийн болон хууль хэрэглээний тайлбарт өөрчлөлт оруулсан байна. Компанийн “нэмж төлөгдсөн капитал” данснаас гүйлгээ хийж, хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн нь компанийн өөрийн хөрөнгийг бууруулах бус, харин компанийн дотоод капиталын бүтэц өөрчлөгдөж, хувьцаа эзэмшигчид авах ёстой ногдол ашгаа банкны хөрөнгө оруулалт руу шилжүүлж буй хэлбэр тул үүнийг ногдол ашгийн орлого хүртсэнд тооцох нь хууль зүйн үндэслэлтэй.</p> <p>Татварын хариуцлагын тухайд, Татварын ерөнхий хуулийн /2008 оны/ 74 дүгээр зүйлийн 74.1-д заасан татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгч гэдэгт суутган тооцогч хамаарахгүй байхын зэрэгцээ татварын улсын байцаагч нь татвар суутган төлөгч этгээд суутган төлөх үүргээ биелүүлээгүй гэж үзвэл мөн хуулийн 29.1.5-д зааснаар</p>

<sup>27</sup> Нийслэл дэх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 сарын 28-ны өдрийн 221/МА2024/0353 магадлал, [https://shuukh.mn/single\\_case/7924?daterange=2024/01/01%20-%202024/06/24%20&id=2&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/7924?daterange=2024/01/01%20-%202024/06/24%20&id=2&court_cat=3&bb=1)

	шилжүүлсэн орлогод татвар ногдуулж, суутган төлөгчийн хөрөнгөөс /алдангийн хамт/ нөхөн төлүүлэх эрхтэй. Иймд хуулийн этгээдийн шийтгэлийн хуудаст тогтоосон төлбөрөөс 826,069,590.00 төгрөгийн торгууль ногдуулсан нь үндэслэлгүй, харин 550,713,060.00 төгрөгийн алданги ногдуулсан нь зөв байх тул анхан шатны шүүхийн шийдвэрийн холбогдох хэсэгт өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ.
<b>Улсын дээд шүүх<sup>28</sup> /2024 оны 09 сарын 23 /</b>	
Шүүхийн шийдэл	Монгол Улсын Дээд шүүхийн 2024 оны 09 сарын 23-ны өдрийн тогтоолоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.
Үндэслэсэн хуулийн заалт	<p>ХХОАТгХ (2006) 13.4-т "... ногдол ашгийн орлогод хувь нийлүүлсэн хуулийн этгээдээс ашиг хуваах, хувь хүртээх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого, түүний хүү хамаарна.</p> <p>ААНОАТгХ (2006) 4.1.6-д "суутгагч" гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг</p> <p>ААНОАТгХ (2006) 21.5. Энэ хуулийн ... 17.2.7-17.2.9-д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч ... төсөвт шилжүүлнэ.</p>
Хууль хэрэглээ тайлбар	Улсын Дээд шүүхээс хэргийг хянан хэлэлцээд “Х” ХХК нь өөрийн хуримтлагдсан ашгаас бүрдсэн нөөцийн сан болон нэмж төлөгдсөн капитал данснаас нийт 19 тэрбум төгрөгийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн нэр дээрх нэгж хувьцааны үнийг 5,000 төгрөгөөс 8,000 төгрөг болгон өсгөсөн нь “мөнгөн бус хэлбэрээр ногдол ашиг хуваарилсан” агуулгатай гэж эцэслэн дүгнэсэн байна. Энэхүү үйлдэл нь хувьцаа эзэмшигчдийн хувьд эдийн

<sup>28</sup> Улсын дээд шүүхийн 2024 оны 09 сарын 23-ны өдрийн 001/ХТ2024/0084 тогтоол, [https://shuukh.mn/single\\_case/3282?daterange=2024-09-01%20-%202024-09-30&id=3&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/3282?daterange=2024-09-01%20-%202024-09-30&id=3&court_cat=3&bb=1)

	<p>засгийн бодит үр ашиг олж, тэдгээрийн өмчлөх эрхийн үнэлэмж нэмэгдсэн үйл явц бөгөөд хэдийгээр мөнгийг бэлнээр өөртөө аваагүй ч компанийн ашиг хувьцаа эзэмшигчийн хөрөнгө рүү шилжиж эдийн засгийн үр ашиг олсон гэж үзэх үндэслэлтэй.</p> <p>Компани болон түүний хувьцаа эзэмшигчид нь бие даасан татвар төлөгчид тул компанийн үйл ажиллагааны ашгаас эздийн нэгж хувьцааны үнийг өсгөж, үнэт цаасны хэлбэрээр ногдол ашиг тараасан тохиолдолд татвар ногдуулах нь шууд татварын зарчимд нийцнэ. Мөн Банкны тухай хуулиар хүлээсэн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг нь татварын хуулиар хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд Монголбанкны тайлбар нь татварын нарийвчилсан хуулийн зохицуулалтыг орлохгүй юм.</p>
--	---

Монгол Улсын шүүхийн практикт хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл ажиллагааг мөнгөн бус ногдол ашигтай адилтган үзэх эсэх асуудал нь онол болон практикийн хувьд томоохон маргааныг дагуулсаар байна. Үүний тод жишээ нь “Х” ХХК болон Татварын ерөнхий газрын хооронд дөрвөн жилийн турш үргэлжилсэн шүүхийн маргаан юм.

Тус хэргийг хянан шийдвэрлэсэн бүх шатны шүүхээс компанийн өөрийн хөрөнгийн бүтцэд гарч буй өөрчлөлт, тэр дундаа хуримтлагдсан ашгаас хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үйлдлийг “мөнгөн бус хэлбэрээр ногдол ашиг хуваарилсан” гэж дүгнэжээ. Компанийн тухай хуулиар ногдол ашгийг мөнгө, эд хөрөнгийн хэлбэрээр болон үнэт цаасны хэлбэрээр олгож болохоор зохицуулсан байдаг бөгөөд хуримтлагдсан ашгийг хувьцааны нэрлэсэн үнийг зөрүүгээр хувь нийлүүлсэн хөрөнгө рүү төвлөрүүлж буй үйл явцыг шүүхээс “ногдол ашиг хуваарилаад, түүнийгээ буцаан хөрөнгө оруулалт болгон үлдээсэн” гэх логик дарааллаар тайлбарлажээ.

Ийнхүү ААНОАТХ-ийн 9 дүгээр зүйлд заасан “ашиг хуваах, хувь хүртэх хэлбэрээр авсан мөнгөн бус орлого” гэх ойлголтын хүрээнд, хувьцаа эзэмшигч бэлэн мөнгө хүлээн аваагүй ч түүний эзэмшиж буй хувьцааны үнэ цэнэ компанийн хуримтлагдсан ашгийн эх үүсвэрээр нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэж байгаа тул татвар ногдох орлого хэмээн үзэж шүүхээс “Х” ХХК-г ногдол ашиг хувьцаа эзэмшигч нарт олгохдоо суутган төлөгчийн үүргээ биелүүлээгүй гэж дүгнэсэн байна.

## 2.2 Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой шүүхийн шийдвэрт хийсэн нягтлан бодох бүртгэлийн дүн шинжилгээ

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудал нь эрх зүйн зохицуулалтаас гадна Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/-ын суурь үзэл баримтлал, зарчмуудтай салшгүй харилцан хамааралтай байдаг. “Х” ХХК-ийн хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой дээрх шүүхийн шийдвэрт НББОУС-ын үүднээс дүн шинжилгээ хийхэд нэн тэргүүнд “Агуулга хэлбэрээс давамгайлах” (Substance over form)<sup>29</sup> зарчим хөндөгдөнө.

Агуулга хэлбэрээс давамгайлах (Substance over form) зарчмын гол агуулга нь аливаа ажил гүйлгээг санхүүгийн тайлан балансад тусгахдаа нэр томъёонд тулгуурлах бус, тухайн ажил гүйлгээний эдийн засгийн бодит мөн чанар, үр нөлөөнд тулгуурлахад оршино.

**Жишээ нь:** “Х” ХХК-ийн хувьд хуримтлагдсан ашиг болон нэмж төлөгдсөн капитал данснаас нийт 19,797,018,000 төгрөгийг дебетэлж (бууруулж), энгийн хувьцаа дансанд кредит (өгсөж) бичилт хийсэн ажил гүйлгээ нь хуримтлагдсан ашгийг капиталжуулах үйл явц юм. Энэхүү ажил гүйлгээ нь компанийн чөлөөт эх үүсвэрийг байнгын капитал болгон хувиргаж байгаа бөгөөд ингэснээр хувьцаа эзэмшигчдэд ирээдүйд бэлэн мөнгөөр ногдол ашиг хуваарилах боломжийг хязгаарлаж, түүний оронд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны нэрлэсэн үнэ нь 5,000 төгрөгөөс 8,000 төгрөг болгон өсгөснөөр нэгж хувьцааны бодит үнэ цэнийг нэмэгдүүлж буй хэрэг юм.

“Х” ХХК-ийн тохиолдолд хуримтлагдсан ашгийг капиталжуулсан нь компанийн өөрийн хөрөнгийн нэг данснаас нөгөө данс руу шилжүүлсэн төдий бөгөөд компанийн нийт өөрийн хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй буюу хөрөнгө гадагш чиглээгүй байна. Иймд “хэлбэр”-ийн хувьд хуримтлагдсан ашиг данс буурсан боловч “агуулга”-ын хувьд компани болон хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө шилжээгүй юм.

Тухайн ажил гүйлгээний зорилгыг авч үзвэл энэ нь ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилж өгөх бус, харин эсрэгээрээ хувьцаа эзэмшигчдийн авах боломжтой байсан ашгийг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болгон ногдол ашиг хэлбэрээр гаргаж авах боломжийг нь хязгаарласан үйлдэл бөгөөд тухайн ажил гүйлгээний эдийн засгийн бодит

<sup>29</sup> Donald E. Kieso, Jerry J. Weygandt, and Terry D. Warfield, *Intermediate Accounting (IFRS Edition)*, 3rd ed. (John Wiley & Sons, 2020), 48-50 дахь тал

үр нөлөө нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн. Энэхүү ажил гүйлгээний үр дүнд компанийн өөрийн хөрөнгийн нийт дүнд өөрчлөлт ороогүй, харин өөрийн хөрөнгийн доторх дансдын дүнд өөрчлөлт орсон буюу данс хооронд дахин хуваарилалт хийсэн юм. Гэтэл үүнийг ногдол ашиг хуваарилсан хэмээн татвар ногдуулж байгаа нь “Агуулга хэлбэрээс давамгайлах” зарчимтай зөрчилдөж байна.

### Хүснэгт 2.3 “Х” ХХК-ийн өөрийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт

Өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг	Ажил гүйлгээний өмнө	Ажил гүйлгээний өөрчлөлт	Ажил гүйлгээний дараа
Энгийн хувьцаа	30,811,302,000.00	19,797,018,000.00	50,608,320,000.00
Нэмж төлөгдсөн капитал	14,140,923,038.59	(14,140,923,038.59)	0
Хуримтлагдсан ашиг	5,656,094,961.41	(5,656,094,961.41)	0
Нийт өөрийн хөрөнгө	50,608,320,000.00	0	50,608,320,000.00

Мөн хувьцааны нэрлэсэн үнэ өснөөр тухайн хувьцаа эзэмшигчдийн компанид эзэмшиж буй хувь хэмжээ (жишээ нь, 100 хувь эсвэл 50 хувь) өөрчлөгдөхгүй бөгөөд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад хувьцаа эзэмшигчийн хувь хэмжээ өөрчлөгдөөгүй, хөрөнгө борлуулагдаж бодитоор хэрэгжээгүй тохиолдолд татвар ногдох орлого үүсэн онолын үндэслэлгүй байдаг.

Иймд тус ажил гүйлгээ нь НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандартын дагуу компанийн өөрийн хөрөнгийн бүтцэд гарсан аливаа өөрчлөлт тул үүнийг “Өмчийн өөрчлөлтийн тайлан”-д үнэн зөвөөр тусгаж, толилуулах шаардлагатай.

### 2.3 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх эрх зүйн зохицуулалт бусад улсын сайн туршлага

Судалгааны энэ хэсэгт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг олон улсад хэрхэн зохицуулсан талаар харьцуулан судлахыг зорилоо. Ингэхдээ эх газрын эрх зүйн төлөөлөл Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, нийтлэг эрх зүйн төлөөлөл Их Британи улс, болон Азийн орнуудаас өөрийн улсын эрх зүйн онцлогтой ойролцоо, холимог эрх зүйн тогтолцоо бүхий Япон улсыг тус тус сонгон авч харьцуулан судалсан болно.

### *Холбооны Бүгд Найрамдах Герман улс*

ХБНГУ-ын компанийн эрх зүйд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зохицуулалтыг компанийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах гэсэн хоёр тулгуур зарчмын хүрээнд нарийвчлан зохицуулдаг. ХБНГУ-ын “Хувьцаат компанийн тухай хууль”<sup>30</sup>-иар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явцыг санхүүгийн болон эрх зүйн үр дагавраас нь хамааран “бодит” болон “нэрлэсэн” гэж хоёр үндсэн хэлбэрт ангилдаг.

- Бодит нэмэгдэл: Компанид гадны эх үүсвэрээс шинэ хөрөнгө оруулалт татах буюу хувьцааны төлбөрийг мөнгөн болон мөнгөн бус хөрөнгөөр төвлөрүүлэх үйл явц юм.
- Нэрлэсэн нэмэгдэл: Компанийн нөөц хөрөнгө болон хуримтлагдсан ашгийг хувь нийлүүлсэн хөрөнгө рүү шилжүүлэн капиталжуулах замаар хийгдэх дотоод санхүүжилтийн хэлбэр юм. Энэ тохиолдолд компани гаднаас нэмэлт хөрөнгө татдаггүй бөгөөд зөвхөн балансын өөрийн хөрөнгө дотор бүтцийн өөрчлөлт хийгддэг.

Дээр дурдсан нэрлэсэн аргаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлэн тайлбарлавал, ХБНГУ-ын “Хувьцаат компанийн тухай хууль”-ийн 207 дугаар зүйлд зааснаар компани нь өөрийн нөөц хөрөнгө болох хуримтлагдсан ашгийг хувь нийлүүлсэн хөрөнгө рүү шилжүүлэх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх эрхтэй<sup>31</sup>. Ийнхүү нэмэгдүүлэхдээ тус хуулийн 215, 216 дугаар зүйлд заасан зохицуулалтыг үндэслэн хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хэрэгжүүлдэг. Энэ нь хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж буй нэгж хувьцааны нэрлэсэн үнэ цэнийг балансын аргаар нэмэгдүүлж, хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн баталгааг бэхжүүлж буй хэлбэр юм.

Хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлэх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явцыг татварын эрх зүйн үүднээс тайлбарлавал, ХБНГУ-ын татварын системд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэрлэсэн аргаар нэмэгдүүлэх үйл явцыг ерөнхий болон тусгай хуулиудын харилцан хамаарал дээр тулгуурлан зохицуулдаг. “Компанийн нөөц хөрөнгөөс дүрмийн санг нэмэгдүүлэх үеийн татварын арга хэмжээний тухай

<sup>30</sup> Aktiengesetz (1965).

<sup>31</sup> Aktiengesetz (1965), art. 207(1), art. 207(2).

(1) The general meeting may resolve to increase the capital stock by converting the capital reserve and retained earnings to capital stock.

(2) Section 182 (1) and section 184 (1) apply accordingly to the resolution and to the application for registration of same. Companies with no-par-value shares may increase their capital stock also without issuing new shares of stock; the resolution adopted on the capital increase must state the nature of the increase.

хууль”<sup>32</sup>-д зааснаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар дүрмийн санг буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд уг өсөлтөд ногдох хэсгийг татвар ногдох орлогод тооцохгүй хэмээн заасан бөгөөд тус зүйл заалт нь “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”<sup>33</sup>-ийн 20 дугаар зүйлд заасан хөрөнгийн орлогын татвар ногдуулах ерөнхий зарчмаас гажсан тусгай зохицуулалт юм. Үүнийг хөрөнгийн орлогын татварт ногдох “мөнгөн бус ногдол ашиг” гэж үзэхгүй байгаа шалтгаан нь хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн хэмжээ бодитоор нэмэгдээгүй, зөвхөн компанийн санхүүгийн баланс дахь нөөц хөрөнгө буюу хуримтлагдсан ашиг нь хувь нийлүүлсэн хөрөнгийн бүрэлдэхүүн рүү шилжсэнд оршино.

Мөн ХБНГУ-ын “Компанийн орлогын албан татварын тухай хууль”<sup>34</sup>-ийн 28 дугаар зүйлд зааснаар хуримтлагдсан ашгаас хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх нь татварын хувьд саармаг (tax neutral) үйлдэл бөгөөд ямар нэгэн ашгийн татвар ногдуулах үндэслэл болдоггүй. Гэсэн хэдий ч тус хуулийн 27 дугаар зүйлд зааснаар капиталжуулсан ашгийг бусад өөрийн хөрөнгөөс зааглан бүртгэл хөтлөх үүргийг хүлээдэг. Энэ нь ирээдүйд тухайн компани хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулсан тохиолдолд тус бууралт нь капиталжуулсан ашгийн буцаан олголт эсэхийг мэдэх боломжийг олгодог.

ХБНГУ-ын хуримтлагдсан ашгаас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг татварын бодлогын үүднээс нэгтгэн дүгнэвэл, ХБНГУ нь ногдол ашгийн албан татвар хувь хүнээс 25 хувийн албан татвар суутгадаг бөгөөд нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой зохицуулалтад тус ногдол ашгийн эрх зүйн зохицуулалт үйлчилдэггүй. Учир нь тухайн компани нь өөрийн хуримтлагдсан ашгаа ногдол ашиг хэлбэрээр гадагшлуулахын оронд компанидаа капитал болгон эргэлдүүлж, хувь нийлүүлсэн хөрөнгийн суурийг бэхжүүлэх нь компанийн санхүүгийн чадавх болон зээлжих зэрэглэлийг дээшлүүлэх, зээлдүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

<sup>32</sup> Gesetz über steuerrechtliche Maßnahmen bei Erhöhung des Nennkapitals aus Gesellschaftsmitteln (1959).

<sup>33</sup> § 20 Einkommensteuergesetz (1934)

(1) ... Die Bezüge gehören nicht zu den Einnahmen, soweit sie aus Ausschüttungen einer Körperschaft stammen, für die Beträge aus dem steuerlichen Einlagekonto im Sinne des § 27 des Körperschaftsteuergesetzes als verwendet gelten...

<sup>34</sup> § 28 Körperschaftsteuergesetz (1976)

(1) Wird das Nennkapital durch Umwandlung von Rücklagen erhöht, so gilt der positive Bestand des steuerlichen Einlagekontos als vor den sonstigen Rücklagen umgewandelt. 2 Maßgeblich ist dabei der sich vor Anwendung des Satzes 1 ergebende Bestand des steuerlichen Einlagekontos zum Schluss des Wirtschaftsjahrs der Rücklagenumwandlung. 3 Enthält das Nennkapital auch Beträge, die ihm durch Umwandlung von sonstigen Rücklagen mit Ausnahme von aus Einlagen der Anteilseigner stammenden Beträgen zugeführt worden sind, so sind diese Teile des Nennkapitals getrennt auszuweisen und gesondert festzustellen (Sonderausweis). 4 § 27 Abs. 2 gilt entsprechend.

## Хүснэгт 2.4 ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

Холбогдох хууль тогтоомж	Зүйл заалт	Зохицуулалтын тайлбар
Хувьцаат компанийн тухай хууль	§ 207-211	Нөөц хөрөнгө буюу хуримтлагдсан ашгийг хувь нийлүүлсэн хөрөнгө рүү шилжүүлэх ерөнхий үндэслэл.
Хувьцаат компанийн тухай хууль	§ 215-216	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх арга хэлбэр. 1. Шинэ хувьцаа гаргах 2. Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх
Компанийн нөөц хөрөнгөөс дүрмийн санг нэмэгдүүлэх үеийн татварын арга хэмжээний тухай хууль	§ 1	Нэрлэсэн өсөлтийг хувь хүний орлогод тооцохгүй байх тусгай зохицуулалт.
Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	§ 20	Хөрөнгийн орлогод ногдох албан татвар. (Нэрлэсэн нэмэгдэл нь "бодит орлого" биш тул хөрөнгийн орлогын албан татвараас чөлөөлөгддөг).
Компанийн орлогын албан татварын тухай хууль	§ 28	Компани татварын саармаг (tax neutral) байдал. Компанийн өөрийн хөрөнгө доторх шилжилт тул ногдол ашгийн албан татвар үүсэхгүй.
Компанийн орлогын албан татварын тухай хууль	§ 27	Капиталжуулсан ашгийг тусад нь бүртгэж, ирээдүйд хувь нийлүүлсэн хөрөнгийг бууруулах үед татвар ногдуулах эсэхийг шийднэ.

**Их Британи улс**

Их Британийн компанийн эрх зүйд хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн засаглал, зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн тулгуур болдог бөгөөд үүнийг 2006 оны “Компанийн тухай хууль”<sup>35</sup>-иар нарийвчлан зохицуулдаг. Тус хуулийн хүрээнд хувь

<sup>35</sup> Companies Act (2006).

нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явц нь зөвхөн гадаад санхүүжилт татах хэрэгсэл бус, компанийн капиталын бүтцийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн цогц механизм юм. Иймд Компанийн тухай хуулийн 617 болон 618<sup>36</sup> дугаар зүйлд зааснаар шинээр хувьцаа гаргах болон урамшууллын хувьцаа гаргах гэсэн үндсэн хоёр хэлбэрийг ашиглаж компани хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлдэг.

- Шинээр хувьцаа гаргах: Компани одоо байгаа хувьцаа эзэмшигчид эсвэл шинэ хөрөнгө оруулагчдаас мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр хөрөнгө татах замаар нэмэлт санхүүжилт босгож хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явц юм.
- Капиталжуулалт хийх: Компани шинээр хувьцаа гаргаж гаднаас хөрөнгө татахгүйгээр хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар одоо байгаа хувьцаа эзэмшигчдэд хувьцааг үнэ төлбөргүй хуваарилах, хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлэх үйл явц юм.

Капиталжуулалт хийх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явц нь компанийн өөрийн хөрөнгийн бүтцийг дотооддоо дахин хуваарилах замаар хэрэгждэг санхүү, эрх зүйн хосолсон нарийн төвөгтэй зохицуулалт юм. Энэхүү үйл ажиллагааны үндсэн мөн чанар нь компани гадны эх үүсвэрээс шинээр хөрөнгө татахгүйгээр, өөрт байгаа нөөц бололцоог ашиглан хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхэд оршдог бөгөөд үүнийг Их Британийн компанийн эрх зүйд “Ашгийг капиталжуулах” гэж тодорхойлдог.

Их Британийн Компанийн тухай хуулийн 618 дугаар зүйлд заасны дагуу компаниуд хувьцаагаа нэгтгэх эсвэл нөөц хөрөнгө болох хуримтлагдсан ашгийг ашиглан хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгөдөө өөрчлөлт оруулах эрхтэй. Энэхүү үйл явцыг хэрэгжүүлэхдээ компанийн холбогдох хууль тогтоомж болон компанийн үүсгэн байгуулах баримт бичиг болох дүрмийг удирдлага болгодог бөгөөд Их Британийн Компанийн тухай хуулийн 550, 551 дүгээр зүйлд<sup>37</sup> зааснаар компанийн дүрэмд капиталжуулалт хийх эрхийг захирлуудад олгосон байхыг шаарддаг. Тодруулбал, тус хуулийн 550 дугаар зүйлийн дагуу нэг ангиллын хувьцаатай хувийн компаниудын захирлууд хувьцаа эзэмшигчдээс нэмэлт зөвшөөрөл авахгүйгээр ашгийг

<sup>36</sup> Companies Act (2006), art, 618(b)

Sub-division or consolidation of shares

(b)consolidate and divide all or any of its share capital into shares of a larger nominal amount than its existing shares.

<sup>37</sup> Companies Act (2006), art, 550.

Where a private company has only one class of shares, the directors may exercise any power of the company—

(a)to allot shares of that class, or

(b)to grant rights to subscribe for or to convert any security into such shares,

капиталжуулах ерөнхий эрхтэй байдаг бол тус хуулийн 551 дүгээр зүйлд зааснаар бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор захирлуудад ашгийг капиталжуулах эрхийг тодорхой хугацаатайгаар олгодог байна. Харин капиталжуулалт хийхэд ашиглах санхүүгийн эх үүсвэрийг тус хуулийн 610 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд хуримтлагдсан ашиг болон нэмж төлөгдсөн капитал данснуудыг ашиглахыг зөвшөөрдөг.

Дээр дурдсан капиталжуулалт хийх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явцыг Их Британийн холбогдох татварын хууль тогтоомжуудын хүрээнд тайлбарлавал, Орлогын албан татварын тухай хуулийн<sup>38</sup> 382-385 дугаар зүйлд зааснаар компани нөөц хөрөнгө болох хуримтлагдсан ашиг дансыг ашиглан хувьцааны нэрлэсэн үнийг өсгөхөд хувьцаа эзэмшигчдэд бэлэн мөнгө хүлээн авах сонголт олгоогүй бол үүнийг орлогын хуваарилаагүй хэмээн үзэж орлогын албан татвар ногдуулдаггүй. Учир нь энэхүү үйл явцад хувьцаа эзэмшигчийн гар дээр бодит бэлэн мөнгө ирээгүй, зөвхөн түүний эзэмшиж буй хөрөнгийн “нэрлэсэн үнэ” нягтлан бодох бүртгэлийн аргаар өссөн тул үүнийг "чанартай бус хуваарилалт" (Non-qualifying distribution) гэж үзэж, орлогын татвараас чөлөөлдөг байна. Харин хувьцаа эзэмшигчид бэлэн мөнгө эсвэл хувьцааны үнэ цэнийг өсгөх сонголтын аль нэгийг санал болгосон тохиолдолд “хувьцаагаар олгох ногдол ашиг” (Stock Dividend) гэж үзэж, орлогын албан татвар ногдуулах үндэслэл болдог.

Их Британийн Татварын алба үүнийг татвараас зайлсхийх зорилгоор ашиглахаас сэргийлж, хэрэв хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үйлдэл нь бодит бизнесийн зорилгогүй, зөвхөн татвар төлөхөөс зайлсхийх үйлдэл гэж үзвэл Орлогын албан татварын тухай хуулийн 684 дүгээр зүйлд зааснаар холбогдох татварыг нөхөн ногдуулах эрхтэй байдаг.

Ийнхүү Их Британийн татварын хууль тогтоомж нь компанийн нөөц хөрөнгө болох хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явцыг хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмждэг нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хамгаалах, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн чухал хөшүүрэг болдогт оршино.

Хүснэгт 2.5 *Их Британи улсын эрх зүйн зохицуулалт*

Холбогдох хууль тогтоомж	Зүйл заалт	Зохицуулалтын агуулга
Компанийн тухай хууль	§ 618	Компани хувьцаагаа нэгтгэх эсвэл хуримтлагдсан ашгийг ашиглан хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх

<sup>38</sup> IncomeTax Act (2007).

		замаар хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулж болно.
Компанийн тухай хууль	§ 550	Нэг ангиллын хувьцаатай компани хувьцаа эзэмшигчдээс нэмэлт зөвшөөрөл авахгүйгээр ашгийг капиталжуулах эрхтэй.
Компанийн тухай хууль	§ 610	Капиталжуулалт хийхэд ашиглах санхүүгийн эх үүсвэр (хуримтлагдсан ашиг болон нэмж төлөгдсөн капитал данс)-ийг ашиглана.
Орлогын албан татварын тухай хууль	§ 382-385	Компани нөөц хөрөнгө болох хуримтлагдсан ашгаа капиталжуулж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөхөд хувьцаа эзэмшигчид бэлэн мөнгө хүлээн авах сонголт олгоогүй бол үүнийг “орлого” гэж үзэхгүй бөгөөд орлогын албан татвар ногдуулахгүй.
Орлогын албан татварын тухай хууль	§ 410	Хувьцаа эзэмшигчид “бэлэн мөнгө” эсвэл “хувьцааны үнэ нэрлэсэн үнийг өсгөх” сонголтын аль нэгийг санал болгосон бол үүнийг “хувьцаагаар олгох ногдол ашиг” гэж үзэж, ногдол ашиг хүлээн авсантай адилтган орлогын албан татвар ногдуулна.
Орлогын албан татварын тухай хууль	§ 684	Хэрэв капиталжуулалт нь бодит бизнесийн зорилгогүй, зөвхөн татвараас зайлсхийх үйлдэл гэж үзвэл татвар нөхөн ногдуулна.

## **Япон улс**

Япон улсын Компанийн тухай хуулийн<sup>39</sup> хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх эрх зүйн зохицуулалт нь компанийн засаглалын уян хатан байдлыг хангах болон зээлдүүлэгчийн эрх ашгийг хамгаалах зарчмын хоорондын тэнцвэрийг хадгалахад чиглэдэг. Тус хуулийн 445 болон 450-451 дүгээр зүйлд зааснаар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг үндсэн хоёр хэлбэрээр хэрэгжүүлдэг. Үүнд,

- Шинээр хувьцаа гаргах замаар хөрөнгө төвлөрүүлэх: Компани шинээр хувьцаа гаргаж, түүнийгээ одоогийн хувьцаа эзэмшигчид эсхүл гуравдагч этгээдэд санал болгох замаар мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө оруулалт татах үйл явц юм. Хөрөнгө оруулагчид хувьцааны үнийг төлснөөр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бодитоор нэмэгддэг.
- Илүүдэл хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэх: Компанийн өөрийн хөрөнгийн бүтэц доторх дахин хуваарилалт бөгөөд энэ нь гаднаас шинэ хөрөнгө татахгүйгээр санхүүгийн үзүүлэлтийг бэхжүүлэх арга юм.

Дээр дурдсан илүүдэл хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явцыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд дэлгэрүүлэн тайлбарлавал, Япон улсын Компанийн тухай хуулийн 450 дугаар зүйлд зааснаар илүүдэл хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэх зохицуулалт нь компанийн өөрийн хөрөнгийн бүтцийг дахин хуваарилах замаар санхүүгийн чадамжаа баталгаажуулах үндсэн механизм болдог. Товчхондоо, компани өөрийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хуримтлагдсан ашгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэд тараахын оронд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө рүүгээ шилжүүлж буй хэрэг юм. Үүний үр дүнд компанийн өөрийн хөрөнгийн хэсэг дотор данс хоорондын хөдөлгөөн хийгдэх боловч энэ нь зээлдүүлэгчийн хувьд компанийн төлбөрийн чадвар болон хариуцлага хүлээх чадвар нэмэгдэж буй хэлбэр гэж үздэг. Учир нь хувьцаа эзэмшигчдэд хуваарилж болох байсан “чөлөөт” хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн нэг хэсэг болсноор компанийн санхүүгийн баталгааг урт хугацаанд бэхжүүлдэг байна.

Япон улсын Компанийн тухай хуулийн 450 дугаар зүйлд<sup>40</sup> заасан илүүдэл хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэх үйл явцыг татварын эрх зүйн үүднээс авч үзвэл,

<sup>39</sup> Companies Act (2005).

<sup>40</sup> 会社法(2005年)450条 「第四百五十条株式会社は、剰余金の額を減少して、資本金の額を増加することができる。この場合においては、次に掲げる事項を定めなければならない。」

Компанийн орлогын албан татварын тухай хуулийн<sup>41</sup> 2 дугаар зүйлийн 16 дахь хэсэг зааснаар “Татварын зориулалттай капитал болон бусад нөөц” хэмээх суурь ойлголтыг тодорхойлсон байдаг бөгөөд энэхүү зохицуулалтын дагуу илүүдэл хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгө рүү шилжүүлэх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх нь хувьцаа эзэмшигчдээс бодитоор гаргасан шинэ хөрөнгө оруулалт биш тул татвар ногдох орлого үүсгэдэггүй.

Түүнчлэн, Япон улсын Компанийн орлогын албан татварын тухай хуулийн<sup>42</sup> 24 дүгээр зүйлд “Хиймэл ногдол ашиг”-ийн талаар зохицуулсан бөгөөд тус хуулийн зүйл заалтад зааснаар илүүдэл хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэх үед хувьцаа эзэмшигчид ямар нэгэн бэлэн мөнгө болон биет хөрөнгө бодитоор олгогддоггүй тул хувьцаа эзэмшигчид эдийн засгийн үр ашиг бий болоогүй гэж үзнэ. Иймд энэ тохиолдолд “Хиймэл ногдол ашиг” үүсэхгүй бөгөөд татвар ногдохгүй. Харин ийнхүү капиталжуулсан хөрөнгийг дараа нь хувьцаа эзэмшигчид бэлэн мөнгөөр буцаан олгох үед тус хуулийн 24 дүгээр зүйл заасан “Хиймэл ногдол ашиг” гэж үзэж татвар ногдуулах үндэслэл болно.

#### Хүснэгт 2.6 Япон улсын эрх зүйн зохицуулалт

Холбогдох хууль тогтоомж	Зүйл заалт	Зохицуулалтын агуулга
Компанийн тухай хууль	§ 450	Илүүдэл хөрөнгийг хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлж, капиталын хэмжээг нэмэгдүүлэх үйл явцыг зохицуулна.
Компанийн орлогын албан татварын тухай хууль	§ 2.16	“Татварын зориулалттай капитал болон бусад нөөц”-ийг зохицуулсан. Илүүдэл хөрөнгийг капитал руу шилжүүлэх нь хувьцаа эзэмшигчээс гаргасан шинэ хөрөнгө оруулалт биш тул татвар ногдох орлого үүсэхгүй.

<sup>41</sup> 法人税法(1994年)2条 「十六資本金等の額 法人（各連結事業年度の連結所得に対する法人税を課される連結事業年度の連結法人（以下この条において「連結申告法人」という。）を除く。）が株主等から出資を受けた金額として政令で定める金額をいう。」

<sup>42</sup> 法人税法(1994年)24条 「第二十四条法人（公益法人等及び人格のない社団等を除く。以下この条において同じ。）の株主等である内国法人が当該法人の次に掲げる事由により金銭その他の資産の交付を受けた場合において、その金銭の額及び金銭以外の資産の価額の合計額が当該法人の資本金等の額又は連結個別資本金等の額のうちその交付の基因となつた当該法人の株式又は出資に対応する部分の金額を超えるときは、この法律の規定の適用については、その超える部分の金額は、前条第一項第一号に掲げる金額とみなす。」

Компанийн орлогын албан татварын тухай хууль	§ 24	Капиталжуулсан хөрөнгийг дараа нь хувьцаа эзэмшигчид бэлэн мөнгөөр буцаан олгох үед “Хиймэл ногдол ашиг” гэж үзэж татвар ногдуулна.
--	------	---

### Бүлгийн дүгнэлт:

Энэхүү судалгааны бүлгийн хүрээнд хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон түүнд хууль хэрэглээний болон нягтлан бодох бүртгэлийн үр дагаврын шинжилгээ хийж, бусад улсын сайн туршлагатай харьцуулан судаллаа.

Өнөөгийн Монгол Улсын шүүхийн практикт хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх үйл явцыг “мөнгөн бус хэлбэрээр ногдол ашиг хуваарилсан” гэж үзэж, татвар ногдох орлого хэмээн тодорхойлж байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн суурь зарчим болох “агуулга хэлбэрээс давамгайлах” зарчимтай зөрчилдөж байгаа бөгөөд компанийн өөрийн хөрөнгийн бүтэц дотор дансны дотоод шилжилт хийгдсэнээс бус хувьцаа эзэмшигчдэд эдийн засгийн бодит орлого олгогдоогүй юм.

Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой бусад улсын харьцуулсан судалгаанаас үзэхэд ХБНГУ, Их Британи болон Япон улсуудад хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг татварын бодлогоор тусгайлан дэмждэг төдийгүй уг ажил гүйлгээний дараа үүсэх эрх зүйн болон татварын үр дагавар, хүлээх хариуцлагыг холбогдох хууль тогтоомждоо нарийвчлан зохицуулсан байна. Тус улсууд нь уг харилцааг компанийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах үндсэн хөшүүрэг гэж үзэж анхдагч үйлдэл болох хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх явцад татварын дарамт үүсгэдэггүй, харин дараа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бууруулах үеийн үр дагавартай холбоотой зохицуулалтыг нарийвчлан хуульчилж өгснөөр эрх зүйн тодорхой байдлыг бий болгодог байна.

## ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын хүрээнд хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх үеийн зохицуулалтыг эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн үр дагаврын үүднээс шинжлэн судаллаа. Компанийн хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр нь зөвхөн санхүүгийн техникийн шинжтэй нягтлан бодох бүртгэлийн үйлдэл бус, тухайн компанийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, зээлжих зэрэглэлийг дээшлүүлж хөрөнгө оруулагчдын итгэлцлийг нэмэгдүүлэх стратегийн өндөр ач холбогдолтой шийдвэр гаргалт юм.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт хувь нийлүүлсэн хөрөнгийг нийт гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээр тодорхойлохоор хуульчилсан. Гэвч уг зохицуулалтад хувьцааны зах зээлийн үнэ болон нэрлэсэн үнийн зөрүүгээс үүсэх “нэмж төлөгдсөн капитал”-ыг тусгайлан зохицуулаагүй нь хууль хэрэглээний тодорхой бус байдлыг бий болгож байна. Түүнчлэн Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх арга хэлбэрийг хуульчилсан бөгөөд ингэхдээ хуримтлагдсан ашгийг капиталжуулж хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үеийн эрх зүйн үр дагаврыг нарийвчлан зохицуулаагүй байгаа нь практикт маргаан үүсэх гол шалтгаан болж байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын шүүхийн практикт хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөсөн үйлдлийг “мөнгөн бус хэлбэрээр олгосон ногдол ашиг” гэж тайлбарлан шийдвэрлэж татвар ногдуулж байгаа үйлдэл нь нягтлан бодох бүртгэлийн “агуулга нь хэлбэрээсээ давамгайлах” суурь зарчимтай зөрчилдөж байгаа болно. Уг ажил гүйлгээний эдийн засгийн бодит агуулга нь хувьцаа эзэмшигчид шинээр хөрөнгө шилжүүлэн олгож буй хэрэг бус, харин компанийн дотоод өөрийн хөрөнгийн бүтэц доторх дансны ангиллын шилжилт бөгөөд компанийн нийт өөрийн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй. Харин өөрийн хөрөнгийн бүтцэд гарч буй дотоод шилжилтийг бодит орлого гэж үзэж байгаа нь татвар төлөгчдөд санхүүгийн дарамт үүсгэж, улмаар компанийн засаглалыг хязгаарлах нөхцөл болж байна.

Харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээнд ХБНГУ, Их Британи болон Япон улсуудын хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлэх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхтэй холбоотой компанийн болон татварын эрх зүйн зохицуулалтуудыг харьцуулан судалсан бөгөөд тус улсууд нь хуримтлагдсан ашгаас хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхтэй холбоотой үр

дагаврын тусгайлан хуульчилж, үүнд татвар ногдуулдаггүй. Учир нь тус улсууд нь уг шийдвэрийг татварын зорилгоор бус, компанийн засаглалыг оновчтой болгох арга хэрэгсэл хэмээн үздэгт оршино.

## САНАЛ

Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх шийдвэрийн эрх зүйн болон нягтлан бодох бүртгэлийн холбогдох зохицуулалтыг судалж, тус шийдвэртэй холбоотой шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний үр дагаврын дүн шинжилгээ хийж маргаантай асуудлыг тодорхойлон, бусад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсныг тус тус үндэслэн судлаачийн хувьд дараах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах саналтай байна. Үүнд:

1. Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлд хувьцааны нэрлэсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүсэх “нэмж төлөгдсөн капитал”-ыг хувь нийлүүлсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тусгайлан хуульчлах.
2. Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд хуримтлагдсан ашгийг капиталжуулах замаар хувьцааны нэрлэсэн үнийг өсгөж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үйл явцыг нарийвчлан тусгах.
3. Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх зохицуулалтын хүрээнд “капиталжуулалт” болон “ногдол ашиг”-ийн ялгаа заагийг тодорхой болгож, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох зорилгоор Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар гаргах.
4. ХБНГУ, Их Британи, Япон зэрэг улсуудын сайн туршлагад үндэслэн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх замаар санхүүгийн чадавхаа сайжруулах, зээлжих зэрэглэлийг дээшлүүлэхэд чиглэсэн шийдвэрийг татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх.
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон холбогдох бусад татварын хууль тогтоомжид ашгийг капиталжуулах үйл ажиллагаанаас үүдэн бий болох татвараас зайлсхийх сөрөг үр дагаврыг нарийвчлан тусгаж, хуульчлан зохицуулах.

## НОМ ЗҮЙ

### 1. Эрх зүйн эх сурвалж

1. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006 он.
2. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019 он.
3. Компанийн тухай хууль, 2011 он.
4. Татварын ерөнхий хууль, 20008 он.
5. Татварын ерөнхий хууль, 2019 он.
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 2006 он.
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 2019 он.
8. Улсын дээд шүүхийн 2024 оны 09 сарын 23 өдрийн 001/ХТ2024/0084 тогтоол.

### Монгол хэл дээрх эх сурвалж :

#### 2. Ном, сурах бичиг

1. Гүнсэнгийн Алтанзаяа, *Татварын бүртгэл*. 2015 он.
2. Гүнсэнгийн Алтанзаяа, *Татвар*. 2020 он.
3. Дамбаачүлтэмийн Байлхүү, Ганхуягийн Давааням, *Компанийн тухай хуулийн тайлбар*. 2023 он.
4. Ганхуягийн Давааням, *Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт*. 2021 он.
5. Ганхуягийн Давааням, *Компанийн эрх зүйн онол, практик*. 2023 он.
6. Жамъянжавын Нямсүрэн, Намсрайн Шинэ-Өлзий, *Нягтлан бодох бүртгэлийн үндэс*. 2023 он.
7. Монголбанк, Санхүү эдийн засгийн их сургууль. *Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь*. 2025 он.
8. Очи-Ай Сэйчи. *Компанийн эрх зүйн үндсэн ойлголт*. 2017 он.

### Гадаад хэл дээрх эх сурвалж :

#### А. Англи хэл дээрх эх сурвалж

1. Armour, J., Hansmann, H., & Kraakman, R. *The Anatomy of Corporate Law: A Comparative and Functional Approach. 3rd Edition*. (Oxford: Oxford University Press, 2017 он) .
2. Davies, P. L., & Worthington, S. *Gower's Principles of Modern Company Law. 11th Edition*. (London: Sweet & Maxwell, 2021 он) .
3. Gullifer, L., & Payne, J. *Corporate Finance Law: Principles and Policy. 3rd Edition*. (Oxford: Hart Publishing, 2020 он) .

4. Kieso, D. E., Weygandt, J. J., & Warfield, T. D. *Intermediate Accounting*. 18th Edition. (Hoboken: Wiley, 2022 он) .
5. Mayson, S. W., French, D., & Ryan, C. L. *Mayson, French & Ryan on Company Law*. 38th Edition. (Oxford: Oxford University Press, 2022 он) .
6. Pettit, B. *Company Law*. 5th Edition. (Harlow: Pearson Education Limited, 2018 он)
7. *Income Tax (Trading and Other Income)*, (2005).
8. *Income Tax Act 2007*, (2007).
9. *Companies Act 2006*, (2006).

**Б. Герман хэл дээрх эх сурвалж**

1. Aktiengesetz [AktG] [Stock Corporation Act], Sept. 6, 1965, BGBI. I at 1089, as amended. (1965).
2. Aktiengesetz [AktG] [Stock Corporation Act], Sept. 6, 1965, BGBI. I at 1089, as amended. (1965).
3. Körperschaftsteuergesetz [KStG] [Corporation Tax Act], Oct. 16, 1934, BGBI. I at 1031, as amended. (1934).
4. Gesetz über steuerliche Maßnahmen bei Erhöhung des Nominalkapitals aus Gesellschaftsmitteln [KapErhStG] (1967). BGBI. I S. 977, as amended.

**В. Япон хэл дээрх эх сурвалж**

1. *Companies Act*, Act No. 86 of 2005. (2005). Ministry of Justice, Japan.
2. *Corporation Tax Act*, Act No. 34 of 1965. (1965). Ministry of Justice, Japan.